

2021 Бондын Санал Хураалт

1. Метро ба Тээвэр

АСУУЛТ: Арлингтон Дүүрэг \$38,700,000 ам.долларын үндсэн дүн бүхий өр тавьж ерөнхий үүргийн бонд гарган бусад боломжит хөрөнгийг нэмэрлэн Вашингтон Метрополийн Хэсгийн Транзитын Газрын орчны төслүүд болон бусад транзит, явган хүн, зам, тээврийн төслүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй юу?

ТАЙЛБАР:

Энэхүү санхүүжилтийн саналаар Дүүрэг даяарх янз бүрийн тээвэр, зам, явган хүний замыг сайжруулах болон транзитын төслүүдийг санхүүжүүлнэ. Энэхүү саналын хүрээнд Вашингтон Метрополийн Хэсгийн Транзит / Метрогийн орчин сайжруулах хөтөлбөрийн хэсгийг \$20.7 сая ам.доллар, зам талбайд хатуу хучилт хийх зардлын хэсгийг \$17.5 сая ам.доллар, гүүрний засвар солилтыг \$0.5 сая ам.доллороор санхүүжүүлнэ.

2021 Бондын Санал Хураалт

2. Орон нутгийн парк, чөлөөт цаг өнгөрүүлэх газар

АСУУЛТ: Арлингтон Дүүрэг \$6,800,000 ам.долларын үндсэн дүн бүхий өр тавьж ерөнхий үүргийн бонд гарган бусад боломжит хөрөнгийг нэмэрлэн орон нутгийн парк, чөлөөт цаг өнгөрүүлэх газрын орчин сайжруулах төслүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй юу?

ТАЙЛБАР:

Энэхүү саналаар янз бүрийн парк, чөлөөт цаг өнгөрүүлэх газрын төслүүдийг санхүүжүүлнэ. Саналын хүрээнд Bluemont Парк Теннисийн Талбайн Комплексийг \$5.0 сая ам.доллар, жим ба гүүрийг орчин үежүүлэх хөтөлбөрийг \$1.0 сая ам.доллар, Арлингтон Boathouse-г \$0.8 сая ам.доллараар санхүүжүүлнэ. Дүүргийн зөвлөл нь бондын хөрөнгийг Дүүргийн Амьдрах Орчин Сайжруулах Төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай, зүйтэй гэж үзсэн тохиолдолд бусад парк, чөлөөт цаг өнгөрүүлэх газрын төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглаж болно.

2021 Бондын Санал Хураалт

3. Орчны дэд бүтэц

АСУУЛТ: Арлингтон Дүүрэг \$17,035,000 ам.долларын үндсэн дүн бүхий өр тавьж ерөнхий үүргийн бонд гарган бусад боломжит хөрөнгийг нэмэрлэн Хөршийн Хамгаалал, Шүүхийн Ордны хэсгийн Дүүргийн эзэмшлийн барилга байгууламжууд, Дүүргийн бусад дэд бүтцийг сайжруулах болон бусад янз бүрийн амьдрах орчин сайжруулах төслүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй юу?

ТАЙЛБАР:

Энэхүү саналаар янз бүрийн Дүүргийн дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлнэ. Саналын хүрээнд Шүүхийн Ордны Комплексийн Шинэчлэл, Дэд бүтцийг \$8.0 сая ам.доллар, барилга байгууламжийн засвар үйлчилгээний төслүүдийг \$4.6 сая ам.доллар, Хөршийн Хамгааллыг \$2.0 сая ам.доллар, Шүүх / Цагдаагийн барилгуудын сайжруулалтыг \$1.8 сая ам.доллар, Quincy Пропертигийн дахин төлөвлөлтийг \$0.7 сая ам.доллараар санхүүжүүлнэ. Дүүргийн зөвлөл нь бондын хөрөнгийг Дүүргийн Амьдрах Орчин Сайжруулах Төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай, зүйтэй гэж үзсэн тохиолдолд бусад Дүүрэг болон нутаг дэвсгэрийн дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглаж болно.

2021 Бондын Санал Хураалт

4. Арлингтон Нийтийн Сургуулиуд

АСУУЛТ: Арлингтон Дүүрэг \$23,010,000 ам.долларын үндсэн дүн бүхий өр

тавьж ерөнхий үүргийн бонд гарган бусад боломжит хөрөнгийг нэмэрлэн

Арлингтон Нийтийн Сургуулиудын орчин сайжруулах төслүүдийг санхүүжүүлэх

нь зүйтэй юу?

ТАЙЛБАР:

Энэхүү саналаар Арлингтон Нийтийн Сургуулиудын орчин сайжруулах төслүүдийг санхүүжүүлнэ:

- Campbell, Drew, and Randolph, Long Branch, and Hoffman-Boston Бага сургуулиуд, Swanson ба Kenmore Дунд сургуулиудын барилгыг сэргээн гал тогоог шинэчлэх, Langston Ахлах Сургуулийн Үргэлжлэлийн Хөтөлбөр (\$11,620,000)
- Heights Барилгын 2-р үе шат (\$11,390,000)

Сургуулийн зөвлөл нь бондын хөрөнгийг Сургуулийн Зөвлөлийн Орчин Сайжруулах Төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай, зүйтэй гэж үзсэн тохиолдолд сургуулийн бусад төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглаж болно.